

Living the Lotus 5

Buddhism in Everyday Life

2025
VOL. 236



**Бангладеш, Тайван, Энэтхэг, Бразилын салбарын гишүүд Их ариун
оронд Бурхан багшийн мэндэлсэн өдрийн ёслолд оролцов**



**Living the Lotus
Vol. 236 (2025.05)**

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Эцэг эхийн ач

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



“Аавуудын өдөр” ба “Ээжүүдийн өдөр”

Японы Эдогийн үе (1603-1868)-ийн сүүлээр Америкыг өмнөд, хойд гэж хоёр хуваахад хүргэсэн боолын системтэй холбоотой мөргөлдөөн болсон. Тус мөргөлдөөний дараахан нэгэн эмэгтэй цаашид нөхөр, хүүхдээ дайны талбар руу явуулахыг эрс эсэргүүцнэ гэсэн зорилготой “Эхийн тунхаглал” гэгчийг зарласан нь эдүгээ “Ээжүүдийн өдөр” (Японд 5-р сарын 2 дахь бүтэнсэйн) болсон түүхтэй. Эхийнхээ хайр энэрэлд талархах өдөр ийнхүү бий болсон ажээ. “Аавуудын өдөр” (6-р сарын 3 дахь бүтэнсэйн) ч гэсэн Өмнөд, Хойд Америкын дайнтай огт холбоогүй биш. Цэргийн албанаас бууж ирээд удалгүй эхнэрээ алдаж, зургаан хүүхдээ ганцаараа өсгөсөн аавыгаа хүүхэд нь хүндлэн дээдлэхийн эрхэнд “Ээжүүдийн өдөр гэж байгаа бол эцэг хүний үйл хэргийг магтаж, талархах өдөр ч гэсэн байх хэрэгтэй.” гэж дуу хоолойгоо өргөснөөр “Аавуудын өдөр” бий болсон гэдэг.

Нэгэн үзүүрт сэтгэлээр гэр бүлээ хайрлаж энэрэх эхийн сэтгэл, үр хүүхдийнх нь эцгээ хүндлэн дээдлэх сэтгэлээс улбаалан эцэг эхдээ талархал илэрхийлэх өдөр үүсэн бий болоод зогсохгүй эдүгээ дэлхийн олон улсад албан ёсоор тэмдэглэдэг болжээ. Энэ түүхэн бодит үнэн нь гэр бүл дэх хайр энэрэл, хүндлэл, талархал нь чухамдаа хүний сэтгэлийг хөгжүүлж, хүнийг бий болгож, хэн бүхний хувьд бахархалтай улс гүрнийг бүтээн байгуулах үндэс суурь болдгийг харуулж байна.

Энэ утгаараа эцэг эхдээ талархал илэрхийлэх өдөр бол миний өмнө дамжуулж байсан “Эцэг нь үр хүүхдийнхээ хүндлэн дээдлэх оршихуй, эх нь элбэрэл хайрын оршихуй байвал зохилтой” гэсэн мэргэдийн үг хийгээд өрх гэр, эцэг эх ямар байвал зохилтойг тунгаан бодож, засаж залруулах сайхан боломж юм.



Эцэг эхээ халамжлахуй ба сансар огторгуй

Эцэг эхийн талаар бодолхийлэн суухдаа “Ёжоокүн” гэдэг эрүүл амьдрахуйн сургаал ном, бас бус анагаах ухааны олон ном судраараа танигдсан философич Каибара Экигэний (1630-1714) “Хүний бие эцэг эхээс үндэстэй, сансар огторгуйгаас эхтэй.” гэдэг үгийг олж уншсан юм. Бидний бие махбод эцэг эхээсээ төрөхөөс ч өмнө “сансар огторгуйгаас эхтэй” байсан гэж юу гэсэн үг юм бол? Ийн бодож байтал онолын физикч эрдэмтэн Сажу Харүо гуайн бичсэн зүйлийг санасан юм. Агуулгыг нь товчхон тайлбарлах юм бол бидний бие махбод огторгуйд дэлбэрсэн одны үртэснээс бүтдэг “байгаль дэлхийн нэг хэсэг” бөгөөд хүн бол “13 тэрбум 800 сая жил зарцуулсан сансар огторгуйн бүтээл” гэсэн байсан. Энэ нь хүмүүс бид сансар огторгуйгаас үүссэнийг нотолж байгаа юм.

Ингээд бодоод үзэхээр бид эцэг эхээс мэндэлсэн нь үнэн боловч эцэг эхээ халамжлах гэдгийг дан ганц аав ээжийгээ хайрлан халамжилж, талархлын бэлэг сэлт өгөхөөр хязгаарлахгүй, өөрөөр хэлбэл бурхны сургаалд ч гэсэн заадагчлан “Огторгуйн агуу энерги”-ийн хүрээнд авч үзэх нь зүйтэй мэт санагдана.

Хэдий ингэж хэлж байгаа ч удахгүй болох гэж буй “Ээжүүдийн өдөр”, “Аавуудын өдөр”-ийн баярын талаар эргээд бодохоор эцэг эхдээ талархсан сэтгэлээ илэрхийлж, бэлэг өгч байсан тод дурсамж үгүй өөрөөсөө ичих сэтгэл төрнө. Эхнэрийнхээ бэлдсэн цэцгийн баглаа гэх зэргийг хамт өгч байсан удаатай ч миний хувьд харин ч эсрэгээрээ үргэлж аав ээжээсээ зөрж, үгийг нь сонсдоггүй байсан дурсамж нь илүү тод мэт. Тийм болохоор Каибара Экигэний амьдарч асан Эдогийн эхэн үеийн философич Накаэ Тоожү (1608-1648)-ын дараах үзэл бодол сэтгэлийг минь тайвшруулна.

“Эцэг эхээ халамжлах гэдэг нь зөвхөн өөрийн биеийг төрүүлсэн аав ээжийгээ хайрлах гэсэн үг бус үүгээр дамжуулж сансар огторгуйн эх үндэстэй нэгдэхэд утга учир нь оршино.” (“Туйлын үнэн бодит үнэний дотор оршдог”, Мори Нобүзоо, Чичи хэвлэлийн газар)

Энэ үгийг би өмнө ч гэсэн танилцуулж байсан. Эцэг эхээ халамжлах гэдэг нь сансар огторгуйн эх үндэстэй хамаатай болохыг энд тов тод бичсэн байгаа болохоор аав ээждээ бэлэг өгч талархал илэрхийлэхдээ маруухан байсан намайг жаахан харж үзэх байх гэж найдъя. Дараа сарын дугаараар эцэг эхээ халамжлах гэдэг үгний утга, түүний учир утгыг бурхны сургаал, эртний мэргэдийн ухаанаас суралцаж, илүү өргөн хүрээнд гүнзгийрүүлэн авч үзэх болно.

Эцэст нь хэлэхэд эцэг эхийнхээ ачаар өнөөдөр бид энэ орчлонд байгаа нь бодит үнэн. Тэр ач буянд талархан бид өөрсдөө өсөж хөгжих чухал ба тэр нь “хүн бэлдэх” гэсэн бидний үндсэн зорилготой холбогдож ирэх юм. Түүнчлэн яавал дэлхий ертөнц эв нэгдэлтэй болох арга замыг хамтдаа бодож тунгаацгаая хэмээн уриалах байна.

«Косей» сэтгүүл, 5-р сарын дугаараас



Нийгэмд хувь нэмэр оруулж, соёлыг өвлүүлэх нь

Косэй номын сан

Косэй номын сан нь 1953 онд нээгдсэн, 60 мянга орчим шашны номыг унших боломжтой соёлын байгууламж юм.

Эдүгээ тус номын санд түүх, гүн ухаан, уран зохиол зэрэг бусад төрлийн ном ч байдаг ба шашны ном, тэр дундаа буддын шашны ном голчилсон нийт 147,300 гаруй номын цуглуулгатай.

Мөн 200 хүний багтаамжтай сургалтын танхимтай бөгөөд орон нутгийн иргэдэд чиглэсэн лекц, судалгааны хурлууд зохион байгуулагддаг.

Косэй Гакүэн сургуулийн уриа нь "Хэрэгжүүлэх болон суралцах хоёр замд чармайн зүтгэ. Хэрэгжүүлж, суралцахгүй бол Бурханы ном гэж үгүй."

Энэхүү урианд хэрэгжүүлэх (туршлага) суралцах (эрдэм мэдлэг)-ыг хослуулан хөгжүүлж, олж авсан мэдлэгээ хүмүүс, нийгмийн сайн сайхан, дэлхийн энх тайвны тусын тулд зориулах зорилго шингэсэн байдаг.



* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Нийгэм, соёлын бусад үйл ажиллагаа



Бяцхан мэдлэг

Косей сэтгэл судлалын институтын зөвлөхүүд нь 4 жилийн сургалтанд хамрагдаж төгсөн, Япон улсын Зөвлөхүүдийн холбооны 2-р зэргийн зөвлөхийн гэрчилгээг авсан мэргэжлийн хүмүүс байдаг. Тиймээс та сэтгэл амар зөвлөгөө авч болно.

Рисшо Косей Кай нийгэмлэг нь өөр олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг.

“Косей сэтгэл судлалын институт” нь сэтгэлзүйн асуудалтай хүмүүст утсаар болон биечлэн зөвлөгөө өгдөг. Түүнчлэн зөвлөх бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж, сургалтыг дүүргэсэн хүмүүс төрөл бүрийн салбарт ажилладаг.

“Гэр бүлийн боловсрол судалгааны институт” нь хүүхдийн баялаг сэтгэлгээг гэр бүлийн хүрээнд хөгжүүлэхийн чухлыг, түүнийгээ бодитоор хэрэгжүүлэх арга замыг сургалт семинараар дамжуулан заадаг.

Спортын хувьд “Косей тулааны урлагийн нийгэмлэг” гэж бий. Энд нутгийн хүүхэд залууст жүдо болон кэндо заадаг.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

Гурван эрхэм үйл

Акагава Кэйичи

Та бүгд сайн байцгаана уу.

Өнгөрсөн сарыг хүртэл огцом хэлбэлзэлтэй байсан цаг агаар эрс өөрчлөгдөж, хүсэн хүлээсэн шинэхэн ургамлын үнэр анхилах хаврын улирал ирлээ. Энэ бол байгаль дэлхийн хаа сайгүй амьдрал цэцэглэн хөгждөг сайхан улирал билээ.

Нивано ерөнхийлөгч Үүсгэн байгуулагчийн олон жилийн турш хийсэн сургаал номыг дэлгэрүүлэх үйлийг дараах байдлаар 3 ангилж нэгтгэн дүгнэснийг та бүхэн сайн мэднэ.

1. Эцэг эхдээ ачлалтай байх
2. Өвөг дээдсээ хүндлэх
3. Бодьсадвагийн үйл хийх

Энэ хорвоод мэндэлсэн хэн бүхэнд “Эцэг эх” гэсэн оршихуй бий. Үүнийг буддын шашинтан бидний сайн мэдэх “Шүтэн барилдлагын сургаал”-аас тодорхой ойлгож болно. Шүтэн барилдлага гэдэг нь “Бүх зүйлс учир шалтгаантай, тэр шалтгааны үр дүнд одоогийн байдал буй болсон” гэх бурхны сургаалын гол үзэл санаа юм. “Эцэг эхээ ачлах”, “Өвөг дээдсээ хүндлэх”, “Бодьсадвагийн үйл хийх” гэсэн 3 үйл нь уг сургаалд суурилдаг.

Үүсгэн байгуулагч бол “эцэг эхийнхээ гүн хайр энхрийлэлд талархах”, “амьдралын үл тасрах гинжин хэлхээг холбож тэтгэсэн өвөг дээдсийнхээ ач буяныг хариулах” гэдгийг бодитоор хэрэгжүүлж үлгэр дуурайлал болсон билээ.

Эцэг эхээ ачлах тухай айлдварыг сонссон энэ сард бидэнд аав ээждээ талархах замаар амь насныхаа эх сурвалж руу сэтгэлээ хандуулах сайхан боломж олдож байна. Энэ талархлын ухамсар яваандаа хөгжиж "өөрийгөө болон бусдыг аз жаргалтай болгох" бодьсадвагийн үйл болон төлөвших нь зүйн хэрэг юм. Энэ сард ч мөн талархах сэтгэлээр номын мөрд хичээнгүйлэн зүтгэцгээе!



Олон улсын хэлтэс “Бурхан багшийн мэндэсэн өдрийн ёслол”-д оролцохоор ирсэн гишүүдийг хүлээж авав.

Дээд тал: Колката салбар, Гаяа хэсгийн гишүүд

Баруун тал: Бангладешийн нийгэмлэгийн гишүүд




Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp